

БАТЛАВ:
АШУУИС-ИЙН МОНГОЛ-ЯПОНЫ ЭМНЭЛГИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Р.ОТГОНБЯЯР

**ЭМНЭЛГИЙН АЛБАН МАЯГТ, ЖУРНАЛ ХЭВЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ: "ЭМНЭЛГИЙН АЛБАН МАЯГТ,
ЖУРНАЛ ХЭВЛҮҮЛЭХ"
ТЕНДЕРИЙН ДУГААР: АШУУИСЭ/2020/006/024

УЛААНБААТАР ХОТ
2020 он

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020.08.26

Тендер шалгаруулалтын нэр: “Эмнэлгийн албан маягт,журнал хэвлүүлэн авах”

Тендерийн дугаар: АШУҮИСЭ/2020/006/024

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол Японы эмнэлэг нь эрх бүхий тендерт оролцогчдоос эмнэлгийн албан маягт, журнал хэвлүүлэн авах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **20,000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн PDF хэлбэрт шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 20,000 /хорин мянга/ төгрөгийг [www.tender.gov.mn-ээ](http://www.tender.gov.mn)р банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.

Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн PDF хэлбэрт шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг **2020 оны 09 -р сарын 02-ны өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 09-р сарын 02-ны өдрийн 11цаг 15 минутанд** Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн хурлын зааланд нээнэ.

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх
дүүрэг, 12-р хороо, Ботаникийн гудамж,
Утас:99221832

АШУҮИС-ийн Монгол-Японы Эмнэлэг

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал 7.1.Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
болгосон үнэ, түүнийг үнэлэх

7.2.Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3.Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1.Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	Тендерт оролцогч эрх бүхий болохыг баталсан дараах баталгааг бичгээр ирүүлнэ. 1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ 2. Шүүхийн тодорхойлолт 3. Санал болгож буй бараа материалын тодорхойлолт, гэрэл зураг, хэвлэмэл материалын катологи 4. Харилцагч банкнаас лавлагаа, авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ. 5. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 1 Дээрх материалууд эх хувиараа байх ба хэрэв хуулбар хувь бол заавал нотариотаар баталгаажсан байх шаардлагатай бөгөөд бүх материал, pdf файлын хэлбэрт шилжүүлэн тод гаргацтай харагдахаар цахимаар ирүүлнэ
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: МУ УБ хот БЗД 12-р хороо Ботаникийн гудамж АШУУИС-н Монгол-Японы эмнэлэг Давхар болон өрөөний дугаар: МЯСЭ-н 3 давхарт 302 Огноо: 2020 оны 09 дугаар сарын 02-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: МУ УБ хот БЗД 12-р хороо Ботаникийн гудамж АШУУИС-н Монгол-Япон сургалтын эмнэлэг Давхар болон өрөөний дугаар: МЯЭ-н 3 давхарт 302 Огноо: 2020 оны 09 дугаар сарын 02-ны өдөр Цаг: 11 цаг 15 минут
ТӨӨЗ 2.3	Дээрх маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: 1. Тендерийн баталгаа шаардлагагүй 2. Захиалгат албан маягтуудыг захиалагчийн гаргаж өгсөн загвар, хийцийн дагуу чанарын андар түвшинд хэвлэх, чанарын гологдол гарсан тохиолдолд засч хэвлэх чадвараа баталгуужуулсан албан бичиг
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Нийт төсөвт өртөг - 23,960,000₮ Багц -1, Албан маягт, дэвтэр- 18,542,400 ₮ Багц-2. Хэвлэмэл материал- 5,417,600₮
ТӨӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй” .
ТӨӨЗ 15.5	Олон улсын худалдааны Incoterms/ Инкотермс -ийн хувилбар:“Incoterms 2010”
ТӨӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)	Бараа хүргэгдэх газар: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо, Ботаникийн гудамж, АШУУИСЭ, В1-р давхар, Эмнэлгийн хэрэгсэл, хангамж түгээлтийн алба
ТӨӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)	“Бараа хүргэгдэх эцсийн цэг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо, Ботаникийн гудамж, АШУУИСЭ, В1-р давхар, эмнэлгийн хэрэгслийн агуулах-G-16
ТӨӨЗ 15.9 (б) (1)	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТӨӨЗ- ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан СІР үнээс гадна дараах үнээр санал болгож болно. Үүнд: байхгүй

ТОӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: тохируулахгүй тогтмол байна.
ТОӨЗ 16.1	Тендерийн валют: Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг байна.
ТОӨЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: шаардлагатай
ТОӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 1 жил, /2019 оны аудитаар баталгаажсан тайлан /
ТОӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 1 жил
ТОӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Шаардлагатай (шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг буцаан сольж өгөх шаардлагатай)
ТОӨЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
ТОӨЗ 18.2 (б)	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: Бүх багцын хувьд ижил сүүлийн 1 жил
ТОӨЗ 18.2 (в)	Гэрээгүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэнтоног төхөөрөмжийн жагсаалт: шаардлагагүй.
ТОӨЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Багц тус бүрийн хувьд санал болгосон үнийн дүнгийнхээ 50%-аас багагүй байх
ТОӨЗ 18.2 (д)	Ашигтай ажилласан байх жилийн тоо: үүлийн 1 жил байна.

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Албан маягт, дэвтэрний нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Техникийн нөхцөл
1	Чиглүүлэх хуудас	ш	5,000	
2	Бүртгэлийн хуудас	ш	5,000	
3	Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас	ш	100	АМ-4
4	Хорт хавдрыг мэдээлэх хуудас	ш	100	АМ-5
5	Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ	ш	50	АМ-7
6	Эмнэлгийн магадлагаа	ш	500	АМ-8
7	Энгийн эмийн жор	ш	2,000	АМ-9А
8	Мансууруулах эмийн жор	ш	1,000	АМ-9Б
9	Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас	ш	500	АМ-13А
10	Эмнэлгээс өвчтөн илгээх хуудас	ш	500	АМ-13Б
11	Шинжилгээнд явуулах бичиг	ш	5,000	АМ-21 (А-Г)
12	Лабораторийн шинжилгээний хуудсууд	ш	7,000	АМ-22 (А-Н)
13	Сэргээн засах эмчилгээний карт	ш	2,000	АМ-25А
14	Өвчний түүх /халууны хуудас, эмийн хуудас, сувилгааны тэмдэглэл, амин үзүүлэлтийг үзэх хуудас/	ш	3,000	СТ-1А
15	Өвчний түүх /хүүхдийн/	ш	1,000	СТ-1Б
16	Эрчимт эмчилгээний тасаг өвчтөн хүлээн авсан эмчийн тэмдэглэл	ш	600	СҮАЗ
17	Ажилбарын тэмдэглэл	ш	2,000	СҮАЗ
18	ЭЭТ өвчтөний зорилтот эмчилгээний хуудас	ш	2,000	СҮАЗ
19	ХТН шинжилгээний хуудас	ш	100	ЭТЛ
20	амьсгалын аппараттай үйлчлүүлэгчдын дунд уушигны хатгалгааг тандах	ш	2,000	А/611
21	шээлгүүртэй үйлчлүүлэгчдийн дунд бөөр шээсний замын халдварын тандах хуудас	ш	2,000	
22	Судасны гууртай үйлчлүүлэгчдийн халдварын шинж тэмдгээр тандах хуудас	ш	2,000	
23	Амилуулах тусламжийн хуудас	ш	500	
24	Яаралтай тусламжийн хуудас /насанд хүрэгчид/	ш	2,500	
25	Яаралтай тусламжийн хуудас /хүүхэд/	ш	500	А-611
26	Тээвэрлэх үеийн хяналтын хуудас	ш	200	А/611

27	Эрчимт эмчилгээний хяналтын хуудас	Ш	8,000	A/611
28	Үйлчлүүлэгч шилжүүлэх хуудас/сувилагч/	Ш	3,500	ОЭДС-2
29	Эрчимт эмчилгээний зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	A/611
30	Төвийн венд гуурс тавих ажилбар хийх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
31	Артерын судсанд гуурс тавих ажилбар хийх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
32	Зохиомол амьсгалын аппаратнад авах зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
33	Цээжний хөндийд гуурс тавих ажилбар хийх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
34	Кардиоверси хийх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
35	Гемодиализ эмчилгээ хийх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
36	Уушигны артерд гуурс тавих зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
37	трахеостомийн ажилбар хийх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
38	Нугасны хөндийд хатгалт хийх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
39	Гемодиализийн гуурс хийх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
40	Хэвлийн хөндийд гуурс байрлуулах зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
41	Перикардийн хөндийд гуурс байрлуулах зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
42	Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх зөвшөөрөл авах маягт	Ш	500	
43	Өөрийн хүсэлтээр эмнэлгээс гарах тухай зөвшөөрлийн хуудас	Ш	500	
44	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг	Ш	500	
45	Эрчимт эмчилгээний хяналтын хуудас	Ш	1,000	СТ-1А,Б Хавсралт 4
46	Эрчимт эмчилгээний зөвшөөрлийн хуудас	Ш	300	
47	Мэдээгүйжүүлэгч эмчийн үзлэг, мэдээ алдуулалтын явц, сэрээх үеийн хяналтын хуудас	Ш	1,000	СТ-1Б Хавсралт 5А
48	Сэрээх үеийн хяналтын хуудас / хүүхэд /	Ш	1,000	СТ-1Б Хавсралт 5Б
49	Мэс заслын тэмдэглэл	Ш	1,000	СТ-1А,Б Хавсралт 6
50	Яаралтай тусламж үйлчилгээний хуудас	Ш	10,000	СТ-1А,Б Хавсралт 7
51	Эмч дуудах хуудас	Ш	250	СТ-13
52	Цус цусан бүтээгдэхүүнийг сэлбэсэн протокол	Ш	1,000	СТ-14
53	Цус цусан бүтээгдэхүүн захиалах маягт	Ш	1,000	СТ-15
54	Цусны албанд шинжилгээний сорьц хүргүүлэх маягт	Ш	1,000	СТ-16

55	Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийг мэдээлэх маягт	Ш	250	СТ-17
56	Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх зөвшөөрөл авах маягт	Ш	1,000	СТ-18
57	Түргэн тусламжийн дуудлагын хуудас	Ш	2,500	СТ-21А
58	Халдвартай өвчний тусгаарлалт, халдваргүйтгэлийн дуудлагын хуудас	Ш	1,000	СТ-21Б
59	Яаралтай тусламжийн эмчийн ажлын өдөр тутмын тооцооны хуудас	Ш	1,000	СТ-22
60	Алсын дуудлагын хуудас	Ш	250	СТ-23
61	Эмийн захиалгын түүвэр	Ш	1,000	СТ-24
62	Нэг удаагийн зүү тариур, хог хаягдлын устгалын тандалт	Ш	1,000	СТ-26
63	Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ хяналтын карт	Ш	200	СҮ-2
64	Цэрний шинжилгээний хуудас	Ш	100	СҮ-3
65	Өсгөвөрлөх шинжилгээний хуудас	Ш	100	СҮ-4
66	Сүрьеэтэй өвчтнийг шилжүүлэх хуудас	Ш	100	СҮ-5
67	Сүрьеэ өвчний голомтын тархвар судалгааны хуудас	Ш	100	СҮ-7
68	Цус сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийн шалтгааныг судлах маягт	Ш	1,000	ЦТ-6
69	Биопси, мэс заслын сорьцын шинжилгээний илгээлт	Ш	1,000	ЭС-3
70	Үйлчлүүлэгчийг ялган таних заавар	Ш	1,000	
71	Унах эрсдлийн үнэлгээний хуудас (насанд хүрэгчид болон хүүхэд)	Ш	1,000	
72	Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийг хянах хуудас СТ-1А/Б	Ш	1,000	
73	Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас	Ш	1,000	
74	Сувилахуйн суурь үнэлгээ	Ш	1,000	
75	Сувилахуйн үнэлгээний хуудас	Ш	1,000	
76	Сувилгааны тэмдэглэл	Ш	1,000	
77	Хэвтэн эмчлүүлэгчийн амаар эм уух чадварын үнэлгээний хуудас	Ш	1,000	
78	Шим тэжээлийн дутагдлын эрсдлийг үнэлэх үнэлгээний хуудас	Ш	1,000	
79	Өвдөлтийг хянах хуудас	Ш	1,000	
80	КАТЗ-ын үнэлгээний хуудас	Ш	1,000	
81	Брандены арьсны үнэлгээ	Ш	1,000	
82	Ричмондын үнэлгээний хуудас	Ш	1,000	

83	Шингэний баланс хянах хуудас	Ш	1,000	
84	Уян зүүний тандалтын хуудас	Ш	1,000	
85	Гуурсны тандалтын хуудас	Ш	1,000	
86	Шарил хүлээлцэх хуудас	Ш	100	
87	Өвчтний түүхийн бүрдэлтийг хянах шалгуур хуудас	Ш	1,000	
88	Хоол боловсруулах дээд замын уян дурангийн ононшилгоо хийлгэх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
89	Хоол боловсруулах доод замын уян дурангийн ононшилгоо хийлгэх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
90	Тайвшруулалттай дуран хийлгэх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
91	Тайвшруулалтын өмнөх асуумж	Ш	1,000	
92	Тайвшруулалтын өмнөх үзлэгийн хуудас	Ш	1,000	
93	Тайвшруулалт болон сэрээх үеийн хяналтын хуудас	Ш	1,000	
94	Тайвшрууллагагүй дурангийн үеийн хяналт	Ш	1,000	
95	Альдретийн үнэлгээ	Ш	1,000	
96	Цес, нойр булчирхайн замын дурангийн шинжилгээ хийлгэх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
97	Эмчилгээний дурангийн ажилбар хийлгэх зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
98	Дурангийн тасагт хэрэглэгдэх асуумжийн хуудас	Ш	1,000	
99	Мэс заслын зөвшөөрлийн хуудас	Ш	1,000	
100	Уламжлалтын эмчийн эмийн жор	Ш	2,000	
101	Зүү засал эмчилгээний карт	Ш	2,000	
102	Төөнө засал эмчилгээний карт	Ш	2,000	
103	Дэвтээлгэ засал эмчилгээний карт	Ш	2,000	
104	Бариа засал эмчилгээний карт	Ш	2,000	
105	Хатгах засал эмчилгээний карт	Ш	2,000	
106	Эмчийн үзлэгийн бүртгэл	Ш	80	
107	БЗДХ-ын кабинетын эмчийн үзлэгийн бүртгэл	Ш	4	100 хуудастай
108	Компьютер томографийн шинжилгээний бүртгэл	Ш	4	100 хуудастай
109	Үйл оношийн шинжилгээний дэвтэр	Ш	4	100 хуудастай
110	MRI шинжилгээний бүртгэл	Ш	4	100 хуудастай

111	Эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн бүртгэл	ш	2	100 хуудастай
112	эрчимт эмчилгээний тасгийн мэдээний дэвтэр	ш	2	100 хуудастай
113	Ажилбарын бүртгэл	ш	2	100 хуудастай
114	Яаралтай тусламжийн тасагт үйлчлүүлэгч хүлээн авсан бүртгэлийн дэвтэр	ш	5	100 хуудастай
115	ЯТТ ажиглалтын хэсгийн өвчтөн хүлээн авч үйлчилсэн бүртгэл	ш	3	100 хуудастай
116	ЯТТ ажиглалтын хэсгийн мэдээний дэвтэр	ш	3	100 хуудастай
117	ЯТТ -ийн ариун материалын орлого зарлагын дэвтэр	ш	2	100 хуудастай
118	Тоног төхөөрөмж эд зүйлсийн бүртгэл	ш	2	100 хуудастай
119	тоног төхөөрөмж ашиглалтын бүртгэл	ш	3	100 хуудастай
120	ятг бэлэн байдал шалгах хяналтын дэвтэр /дефибрилятор/	ш	7	100 хуудастай
121	ятг бэлэн байдал шалгах хяналтын дэвтэр/шалгуур хуудас/	ш	7	100 хуудастай
122	Эмчлүүлэгчийн өдөр тутмын тооцооны бүртгэл	ш	2	100 хуудастай
123	Цус цусан бүтээгдэхүүний АВО резус бүлэг тодорхойлох хөтлөгдөх бүртгэл	ш	2	100 хуудастай
124	Үр хөндөлтийн бүртгэл	ш	4	100 хуудастай
125	Үйл оношийн кабинетийн шинжилгээний бүртгэл	ш	80	100 хуудастай
126	Сэргээн засах эмчилгээний бүртгэл	ш	6	100 хуудастай
127	Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагсдын бүртгэл /амбулаторит/	ш	6	100 хуудастай
128	Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагсдын бүртгэл /стационарт/	ш	6	100 хуудастай
129	Эмнэлгийн эмийн санд хөтлөгдөх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын бүртгэл	ш	6	100 хуудастай
130	Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын бүртгэл /амбулаторт/	ш	4	100 хуудастай
131	Тасарсан эмийн бүртгэл	ш	6	100 хуудастай
132	Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн хэрэглээний бүртгэл /тасгийн А шүүгээний дэвтэр/	ш	6	100 хуудастай
133	Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын бүртгэл /эм зүйн албанд/	ш	6	100 хуудастай
134	Гаж нөлөө бүргэн мэдээлэх хуудас /шар хуудсан дээр/	ш	6	100 хуудастай
135	Нөөцийн шүүгээний дэвтэр	ш	6	100 хуудастай
136	Биохимийн шинжилгээний бүртгэл - (JCA-VM6010/C)	ш	10	100 хуудастай
137	Өсгөвөрлөх шинжилгээний бүртгэл	ш	10	100 хуудастай
138	Түрхэцийн шинжилгээний бүртгэл	ш	10	100 хуудастай

139	Цусны ариун чанар тодорхойлох шинжилгээний бүртгэл	ш	10	100 хуудастай
140	Хурдавчилсан сорилын бүртгэл	ш	10	100 хуудастай
141	Иммунологийн шинжилгээний бүртгэл - (HISCL-5000)	ш	10	100 хуудастай
142	Цусны бүлэг тодорхойлох шинжилгээний бүртгэл	ш	10	100 хуудастай
143	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ + WPC+RET+IPF бүртгэл	ш	10	100 хуудастай
144	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ + RET бүртгэл	ш	10	100 хуудастай
145	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ + IPF бүртгэл	ш	10	100 хуудастай
146	Цусны дэлгэрэнгүй шинжилгээний бүртгэл	ш	10	100 хуудастай
147	Ясны хэмийн түрхэцийн шинжилгээний бүртгэл	ш	10	100 хуудастай
148	Захын цусны түрхэцийн шинжилгээний бүртгэл	ш	10	100 хуудастай
149	Цус бүлэгнэлтийн шинжилгээний бүртгэл	ш	10	100 хуудастай
150	Шээсний ерөнхий шинжилгээ - (UC-3500)	ш	10	100 хуудастай
151	Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ - (UC-3500)	ш	10	100 хуудастай
152	Шээсний тунадасны шинжилгээ - (UF-5000)	ш	10	100 хуудастай
153	Биеийн шингэний эсийн шинжилгээ - (UF-5000)	ш	10	100 хуудастай
154	Электролитийн шинжилгээ - (9180 Electrolyte analyzer)	ш	10	100 хуудастай
155	ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний журнал	ш	10	100 хуудастай
156	ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний журнал	ш	10	100 хуудастай
157	Яаралтай шинжилгээний бүртгэл	ш	10	100 хуудастай
158	Лабораторид сорьц хүлээн авсан бүртгэл	ш	10	100 хуудастай
159	Сорьц буцаасан бүртгэл	ш	10	100 хуудастай
160	Сорьц цуглуулах хэсгийн бүртгэл	ш	10	100 хуудастай
161	Бохир, цагаан хэрэглэл хүлээн авах олгох бүртгэл	ш	10	100 хуудастай
162	Ариутгалын бүртгэл, хяналт	ш	10	100 хуудастай
163	Төвлөрсөн ариутгалын тасаг/ нэгж/-т багаж материалыг хүлээн авсан бүртгэлийн хуудас	ш	10	100 хуудастай
164	Багаж, материалыг хүлээн авсан бүртгэлийн хуудас	ш	10	100 хуудастай
165	Эмчлүүлэгсдийн өдөр тутмын тооцооны бүртгэл	ш	8	100 хуудастай
166	Амбулаториор үйлчлүүлэгсдийн бүртгэл	ш	20	100 хуудастай
167	Харуул хамгаалалтын ээлж хүлээлцэх дэвтэр	ш	10	100 хуудастай
168	Сантехникийн ээлж хүлээлцэх дэвтэр	ш	10	100 хуудастай
169	Хөдөлмөр хамгааллын зааварчилгааны дэвтэр	ш	10	100 хуудастай
170	Параметрийн дэвтэр	ш	10	100 хуудастай
171	Дуудлага хүлээн авах дэвтэр	ш	10	100 хуудастай
172	Үйлчлүүлэгч дэмжих албаар үйлчлүүлсэн хүмүүсийн бүртгэл	ш	10	100 хуудастай
173	Бичил цаг уурын бүртгэл	ш	10	100 хуудастай
174	Эрүүл мэнд ариун цэврийн бүртгэл	ш	10	100 хуудастай
175	Цэвэрлэгээ халдваргүйтлийн бүртгэл	ш	10	100 хуудастай

176	Хөргөх төхөөрөмжийн бүртгэл	ш	10	100 хуудастай
177	Хоолны сорьц авалтын бүртгэл	ш	15	100 хуудастай
178	Өдөр тутмын хяналтын бүртгэл	ш	15	100 хуудастай
179	Бараа материал хүлээн авах бүртгэл	ш	15	100 хуудастай
180	Хоолны чанар шалгах бүртгэл	ш	15	100 хуудастай
181	Бараа гаргах бүртгэл	ш	15	100 хуудастай
182	Бараа хүлээн авах бүртгэл	ш	15	100 хуудастай
	Дүн		143,188	
1	А4 хэвлэх материал, өнгөт	ш	5,000	
2	А5 хэвлэх материал, бяцхан ном	ш	2,450	
3	ЯТТ-н боршур, А5	ш	1,000	
4	А6 хэвлэх материал	ш	220	
5	А3 хэвлэх материал	ш	8	
6	Анонас хэвлүүлэх, 2х3	ш	2	
7	Дуугүй хөтөч, эмүлсэн материалтай	ш	3	
8	Ханын хэвлэл, А3	ш	30	
9	Баннер, 200х200	ш	30	
10	Постер, 100х180	ш	60	
11	Катологи, боршур, А5	ш	800	
12	Стикер, хуулаад наадаг, А4	ш	50	
	Дүн		9,653	
	НИЙТ ДҮН		152,841	

- 1. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
- 2. Баглаа, боодол:** Улаанбаатар хот дахь захиалагчийн агуулахад нийлүүлэх шаардлагыг хангасан байх бөгөөд өмнө нь ашиглаж байгаагүй шинэ, капитал засвар хийгээгүй байх шаардлагатай, нийлүүлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн биеэр хүлээлгэн өгч акт үйлдэнэ.
- 3. Бараа хүргэх газар:** Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо Ботаникийн гудамж. МЯСЭмнэлэг

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(**Захиалагч байгууллагын нэр**)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [**санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр**] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [**тоо**] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших** 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт** 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
- 3. Оюуны өмчийн эрх** 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
- 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх** 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 5. Баталгаат засварын хугацаа** 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна.
- 6. Гэрээнд өөрчлөлтөөрчлөхгүй. оруулах** 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг оруулах
- 7. Төлбөр** 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
- 8. Бараа нийлүүлэх хуваарь** 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 9. Алданги оногдуулах** 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах** 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. **Шалгах** 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх болон шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх турших нөхцөлийг заана.]
(ГЕН – 1)

2. **Барааны** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
(ГЕН – 2)
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

3. **Баталгаат** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
засвар
(ГЕН-5) [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]

4. **Төлбөр** 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар
(ГЕН – 7) дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **[100]¹** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

5. **Алданги** 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,1]**
оногдуулах
(ГЕН - 9)² Алдангийн нийт дүн: **[10%-иас ихгүй байна]**

¹Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүнгэрээ нийгүүнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
“АШУҮИС-н Монгол-Япон сургалтын эмнэлэг	
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь; Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

⁴ Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]